

Завхан аймгийн Тэс сумын “Таанат тэс” бэлчээр ашиглагчдын холбоо 2011 оны 4-р сард “Чацаргана” хотолборийн хврээнд аймгийн ХААЖДҮГ-аас зарласан суулгац зээлээр олгох тендерторолцож тосол нь шалгарчээ. Ингэснээр 4,6 сая тогрогийн ортог бүхий 2000 ширхэг суулгацыг авч, 5 жилийн дараа нэг бүрийг нь 2300 тогрогоор тооцож үнийг нь эргэн толох ажээ. Чацарганыг тариалснаас хойш 3 дахь жилээс эхлэн ашгаа огдог юм байна. 2000 бутнаас тариалалтын эрсдэлээс хамаарч 70 хувь нь жимсээ огно гэж тооцвол 1400 бут жимсэлж, 1 бутнаас дунджаар 7 кг, нийт 9800 кг буюу 20 сая орчим тогрогийн ашгийг нэг жилдээ олохоор тооцоолсон байна. Тус тосолд шалгарах болсон нэг үндэслэл нь энэ байгууллага чацаргана тариалалтыг олно нь хийж байсан туршлагатай бөгөөд 2010 онд нэг га газар 500 ширхэг ондор “Чуский” сортын чацарганыг тариалсан нь 95 хувийн ургалттай байгаа юм.

“Таанат тэс” бэлчээр ашиглагчдын холбоо сумын нийт малчдыг 8 бэлчээр ашиглагчдын хэсэг болгон зохион байгуулж, бэлчээрээ тооловж, хуваартай ашиглахын зэрэгцээ унаган байгалаа хамгаалах, орлогыг нь нэмэгдүүлэх вйл ажиллагаануудыг санаачлан хэрэгжүүлдэг. Нэг жишээ сонирхуулахад Тэсийн гол дагуу маш ихээр ургадаг зэрлэг чацарганыг сүүлийн жилүүдэд хэмвэс болц нь гүйцээгвй вед нь түүх, буцыг хугалах, цавчиж жимсийг нь авах зэргээр зохисгвй ашиглаж байжээ. Үүнийг цэгцлэх, зов ашигласнаар тодорхой хэмжээний орлого олох ажилд малчдыг зохион байгуулалттайгаар татан оролцуулж эхэллээ.

Тус холбоо вйл ажиллагаагаа эхлээд гурван жил болж байна. Холбооны тэргүүн С.Гүррагчаа малчдынхаа дэмжлэгийг хүлээсэн энэ мэт олон ажлуудыг санаачлан хэрэгжүүлж байгаа бөгөөд зах зээл, ажиллах хүчин, сумынхаа онцлогийг судалж, тоолологоо гаргасныхаа дагуу эсгий болон эсгий бүтээгдэхүүн вйлдвэрлэх зориулалттай тоног тохооромжийг суурилуулж эхлээд байна. Ингэснээр тус малчны байгууллага ирээдвйд бие даан хогжих нэг боломж бүрдэнэ.